

ШУНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЕХАНИК ИНЖИНЕРИЙН СУРГУУЛЬ
АЕРО-ГИДРО МЕХАНИКИЙН ПРОФЕССОРИЙН БАГ

Эрдэм шинжилгээний ажил

Сэдэв : Залуусын асуудал ба авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Гүйцэтгэсэн : Нисэх Техникийн механикийн ангийн III дамжааны оюутан

Баттулга овогтой Жавхланбаяр

Улаанбаатар хот

2011 он

ГАРЧИГ

Оршил	3
1. Үндсэн ойлголт	4
1.1. Авлига гэж юу вэ	4
1.2. Бид хаана явна вэ?	4
1.3. Судалгааны ажил	5
1.4. Асуултууд	5
2. Асуудал	8
3. Шийдвэрлэлт	9
3.1 Яаж?	10
Дүгнэлт	10
Хавсралт	11

Оршил

Монголын авлигын түвшин хүн ам цөөн манайх шиг жижиг улсын хувьд хэт өндөр үзүүлэлт байгаа бөгөөд энэхүү үзүүлэлтыг бууруулж хараахан чадаагүй байна. Монгол улс энэхүү авлигын түвшинг зөв зохистой аргаар үр дүнтэй бууруулах замыг хайсаар байгаа бөгөөд үүндээ оюутан залуусын туслалцаа дэмжлэгийг мөн адил хүлээж байгаа нь илэрхий. Тиймээс авлигатай тэмцэх газараас зохион байгуулсан энэхүү судалгаанд оролцсоноороо авлига гэж юу болох, залуусын авлигын тухай ойлголтыг судлах, оюутан залуусын санаа бодолыг энэхүү эрдэм шинжилгээний ажилаар дамжуулан танилцуулах чухал үүрэгтэй. Ингэснээр авлигатай тэмцэх газар болон дээд шатны байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагаа явуулахад нь дөхөм болох нь энэхүү судалгааны ажлын гол зорилго юм. Бусад байгууллагууд нь авлигын тухай ойлголт болон баримт мэдээг эрхлэн гаргадаг боловч оюутнуудад ойрхон үйл ажиллагаа ховор. Тиймээс оюутны хүрээнд, боловсролын хүрээнд авлигын хэрэг ямар үзүүлэлттэй байдаг, тэдэнд ямар асуудал тулгамдаж байгааг нээн илрүүлэхэд анхаарсан үйл ажиллагаа бага учир энэхүү судалгааны ажилаар дээрх мэдээллыг олж авах юм.

1. Үндсэн ойлголт

1.1. Авлига гэж юу вэ?

Авлига гэдэг нь Монгол хэлэнд “ёсон бусаар шунаж авсан эд юм” гэсэн тайлбартай байдаг байна. Яах аргагүй энэ бол мэдээж ёс бусаар авсан зүйл гэдгийг иргэд ард түмэн маань мэднэ. Харин Монгол улсын засгийн газар хуулийн төсөлд авлига гэдэг үгийг томъёолохдоо: Авлигын эсрэг хууль 3.1.1 “авлига гэж хуулийн этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ” хэмээн тайлбарласан байдаг. Энэхүү авлига гэгч аюулын харангыг бид ардчилалтай хамт хөгжүүлсээр ирсэн гэдгийг Монголын ардчилалын түүх харуулна. Өнөөдөр энэ авлигал гэдэг зүйлийн тухай асуухад найман настай буурлаас наян настай хөгшид ч “мэднэ” хэмээн хариулах боловч яаж бууруулах талаар хэн ч баттай шийдтэй хариулт хэлж чадахгүй байсаар байна. Бидний авлигын эсрэг хийсэн зүйлүүд гэвэл:

- 1996 онд Авлигын эсрэг хууль батлав.
- 2002 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гаргасан.
- 2005 онд НҮБ-ын “Авлигалын эсрэг конвенци”-д нэгдэн оров.
- 2007 онд Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг авч эхэлсэн.
- 2007 онд Авлигатай тэмцэх газар байгуулагдсан зэрэг институтын хувьд ажилуудийг хийж чадсан. Гэвч авлига гэгч гэмийн цаана гарч чадаагүй л явна.

1.2. Бид хаана явна вэ

Харин авлигын түвшинг хэрхэн бууруулсан байдаг бол гэсэн асуулт гарч ирж байна. Энд судалгаа хийгээд үзэе. Энэ бол олон улсын “Трансперенси Интернешнл” байгууллагаас жил бүр дэлхийн улс орнуудын авлигын индексийг тодорхойлдог судалгаа юм. Авлигын түвшинг 0-10 оноогоор дүгнэж, хамгийн бага авлигатай буюу авлигыг хязгаарлаж чадсан орнууд 10-аас эхэлж, авлигыг дээд зэргээр хөгжүүлсэн улс орон тэг оноо руу уруудах байдлаар тооцож харуулдаг

Он	Монголын оноо	Монголын эзэлсэн байр	Нийт судалгаанд хамрагдсан улс орон
2004	3.0	85	145
2005	3.0	85	159
2006	2.8	99	180
2007	2.8	102	180
2008	3.0	106	180
2009	3.0	120	180
2010	2.7	116	178

Бид дээшлээ нь үгүй доошлоо нь үгүй харагдаж байна. Энэ зүйлд зөвхөн авлигатай тэмцэх газрыг буруутгах хэрэггүй юм. Аль ч салбарт тэр ч байтугай айлд ч тэр авлига гэгч урвагч этгээд ороод ирсэн хоймор нь морилж байгаа. Бүгдыг мөнгөөр хэмжиж сурсан аавтайгаа тоглохын тулд бяцхан охин өөрт нь мөнгө санал болгож байгааг харсан эцэг хэрхэн толгойгоо шаах бол. Согтуу машин жолоодож явсан босс дайрсан нөхөртөө мөнгө шидээд явах хүнд суртал ч байна. Зүгээр л хүний амь тэр боссд мөнгөтэй тэнцүү. Одоо бүгд энэ авлигын эсрэг хөдлөх болжээ.


1.3. Судалгааны ажил

Би оюутан хүн. Манай салбарт авлига, хээл хахууль ямаршуу байдалтай байдаг болохыг би сонирхож багахан судалгааг хамт хичээллэдэг нөхдөөсөө авч үзлээ. Энэхү судалгаанд боловсролын байгууллага тэр дундаа сургуулийн багш, албан хаагчидын дунд авлига, хээл хахууль, хүнд суртал, шудрага бус байдал байдаг уу? Хэрэв байдаг бол ямар хэмжээтэй байдаг болон оюутнууд энэ тал дээр ямар байр суурьтай байдаг талаар асуултууд бэлдсэн.


/ Хавсралт1-ээс судалгааны эх хувийг үзнэ үү /

1.4 Асуултууд


1. Боловсролын байгууллагын багш, албан хаагчдын дунд авлига хүнд суртал бий юу?




2. Та боловсролын байгууллагад авлигал хээл хахууль болон хүнд сурталын хэрэг явдал байдаг гэдгийг хэрхэн мэдэх вэ?




3. Боловсролын байгууллагын ямар албан хаагч авлигал авдаг болон хүнд суртал гаргадаг вэ?




4. Багш нарын зардаг ном болон гарын авлага нь дүнд нөлөөлж байсан удаа бий юу?




5. Та өөрөө багш нарт мөнгө өгөх болон үнэ бүхий зүйлээр дүн гаргуулсан удаа байгаа юу?




6. Сургалтын албаны ажилтангууд ямар үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал гаргадаг вэ?




7. Багш нар таньтай харилцахдаа таагүй зан авир гаргаж байсан удаа бий юу?



8. Хэрэв та 7-р асуултанд тийм гэж хариулсан бол ямар араншин гаргадаг байсан бэ?




9. 10. 11. –р асуулт нээлттэй асуулт байсан бөгөөд энэхүү асуултуудад оюутууд өөрсдийн санал бодолоо чөлөөтэй хуваалцлаа. Тэд өөрсдөндөө тохиолдож байсан авлигын баримтыг хэлэхээс бүгд татгалзсан бөгөөд харин хэрхэн шийдвэрлэх тал дээр бүгд санал бодолоо хэлсэн юм.




2. Асуудал

АНУ-ын Азийн сангаас хагас жил тутамын авлигын түвшин тогтоох судалгаа явуулдаг бөгөөд энэ судалгаанаас харахад Монгол улсад тулгамдаж буй асуудлын 10 орчим хувийг авлига эзэлж байна.



Харин Монгол улсын засгийн газрын төсвийн 0.01 орчим хувьтай тэнцэх хэмжээний мөнгөөр Монгол улс маань аблигатайгаа тэмцэж байна. Монгол улсад

тулгамдаж байгаа асуудлын 10 хувийг шийдвэрлүүлэхэд энэ санхүү хангалттай гэж үү? Харин өндөр хөгжилтэй орнууд болон бусад зарим улсууд авлигын эсрэг үйл ажиллагаандаа засгийн газараасаа 0.3 хувийг авдаг. Ингэж байж л авлигатай тэмцэж чаддаг. Харин манай улс иймэрхүү санхүүгийн тогтолцоон дунд юу хийж чадах бол. Авлигатай тэмцэж чадахгүй байгаа нэг шалтгаан энэ юм болов уу гэж бодох юм. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд Монгол улсад авлигын хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн бэ? гэсэн асуулгад:



Иргэдийн үзэж буйгаар гарт баригдаж нүдэнд үзэгдэх юм огт хийгээгүй болохоор энэхүү дүгнэлтэнд хүрч ийм хариулт өгсөн нь гарцаагүй. Тиймээс гарт баригдаж нүдэнд үзэгдэх зүйлийг илүү хийх хэрэгтэй. Ингэснээр ард түмэн авлигын тухай илүү мэдэж улс оронд энэ талаар ямар үйл явдал болж байна, юу хийгдэж байгаа, ямар хор хохиролтой зэргийг мэдсэнээр авлига авахгүй байх болон авлига өгөхгүй байх нөхцөл бүрдэнэ.

3. Шийдвэрлэлт

Хүн гэдэг сэтгэхүйн амьтан. Хүн хүнтэй харьцаж, хүнээс сурч, хүнд зааж амьдардаг. Энэ холбоог бид нийгэм гэдэг. Хүн нийгмийн амьтан. Тиймээс бид энэ нийгэм гэдэг харилцаан дотроос авлига гэгч хар толбыг авч хаяхын тулд хүмүүсийн харилцаанд гол анхаарал хандуулах хэрэгтэй. Хүний сэтгэл санаа, хүмүүжил болон ой тогтоолт, санамж, туршлага зэрэг нь хүний хийж буй үйлдэлд нөлөөлдөг ганц хүчин зүйл юм. Нэн ялангуяа хүмүүжил болон боловсролд энэхүү ухагдахууныг суулгаж өгөх юм бол цаашид эерэгээр нөлөөлнө гэсэн үг. Амьдралд

хөл тавьж, нийгэмд биеэ авч явж эхэлж буй залууст юу хортой юу хоргүй гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

3.1. Яаж?

Зөвхөн нийгмийн ухааны сургууль биш бусад бүх сургуульд хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх. Ямар ч мэргэжил болон ангид хууль болон ёс зүйн хичээлийг 2-3 кредит цагт хамааруулан оруулж өгөх. Мөн тухайн хичээлд авлига, авлигатай тэмцэх тухай бүлэг лекц, семинарын цагтай байх. Оюутанд бие даалт болгон авлигын хэрэг авлигын хор хөнөөлийг судлуулах зэрэг ажиллагаа явуулахад оюутан залуучууд энэ талаар боловсрох болно. Оюутан хүн бие даалт, судалгаа шинжилгээний ажил түлхүү хийж гүйцэтгэн түүнээс тухайн хичээлийн практик ойлголтыг авч байдаг учраас авлига, шудрага ёсны сэдэвт семинар орж өгсөнөөр хууль хяналт болон авлигын тухай бүх зүйлийг сурч авахад хэрэгтэй. Монголын нийт хүн амын цөөнгүй хувийг оюутнууд эзэлдэг бөгөөд эндээс Монголын ирээдүйн боловсон хүчин төрөн гардаг гэсэн утгаараа энэ соён гэгээрүүлэх үйл ажиллагаа илүү үр дүнтэй юм.

Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд Монголын авлигалын түвшинг бууруулах болон урьдчилан сэргийлэхэд хүн ардыг соён гэгээрүүлэх үйлс илүү ашиг тустай гэж үзэж байна. Үрээ сайн суулгаагүй хэрнээ ургац муу хураалаа хэмээнэ. Суулгасан үрээ услаагүй атал ургах ногоо ургасангүй хэмээх. Ургацаа муу хураасан хойноо хураасан тариа буудайндаа буруу юу чихэхэв. Байгалийн жамаараа ургаад ирсэн ургамлыг яалтай. Муу болгоны толгойг нь тастан хаях уу? Аль эсвэл муухай гэж голоод бүгдыг устгах уу? Харин эсрэгээр үрээ сайн суулгасан, усалгаа сайн авсан ногоо ургахдаа ёстой л алтран халиурна даа. Тиймээс нийгмийн тариа болсон залуусынхаа ургаж буй оюунд нь дусал ч гэсэн цэвэрхэн ёс зүйг шингээж өгвөл энэхүү авлига гээч зүйл тань байхгүй болно. Үрээ сайн суулгаж, үндэсээ сайн усалъя.

НОМ ЗҮЙ

Монголийн авлигын үнэн түүх 2008 он / Жа.Пүрэв, Б.Болд, Ш.Цэрэнпив /

Авлигын эсрэг хууль /2006 он/

Авлигын түвшин тогтоох судалгаа / THE ASIA FOUNDATION 2010 /

Дэлхийн улс орнуудын авлигын индекс / 2010 он /

